

**Д. РАВЖААГИЙН «ХҮНЛЭГ  
ЁСНЫ» СУРГААЛЫН ШИНЭЭР  
ОЛДСОН НЭГЭН ЗОХИОЛ**

**(Д. Равжаагийн мэндэлсний 185 жилийн ойд)  
Р. БЯМБАА**

XIX зууны үеийн монголын яруу найрагч Дулдуйтын Равжаа (1803-1856)-гийн зохиол бүтээлийг олон эрдэмтэд, судлаачид судлан шинжилж, хэвлэн нийтэлж олон түмний хүртээл болгож байна.

Акад. Ц. Дамдинсүрэн, Д. Цагаан<sup>1</sup>, Ч. Алтангэрэл<sup>2</sup> нарын зэрэг эрдэмтдийн нийтэлсэн эмхтгэл болон бусад судалгааны зохиолуудад<sup>3</sup> Равжаагийн нэлээд олон бүтээл орж бүртгэгдэн хэвлэгдсэн боловч тэнд ороогүй зохиол монгол, төвд хэлээр бас мэр сэр байна.

1987. IV сарын дундуур Дорноговь аймгийн Даланжаргалан суманд ажлаар явж байхдаа тус сумын «Идэр» хэсгийн хоньчин, хуучин Мандах сумын харьяат Б. Балжирмаа (54 настай) гуайтай уулзаж өөрт нь хадгалагдаж байгаа Равжаагийн зохиолуудыг үзсэн билээ. Балжирмаа гуай олон жилийн өмнө тэдгээр зохиолуудыг уйгуржин монгол үсгээр бичсэн эхээс цээжилж, мартаггүйн тулд шинэ үсгээр тэмдэглэж авсан юм гэж ярьж байлаа. Тэдгээр зохиолоос «Орчлонгийн алтан товч» гэдэг сургаалыг урьд өмнө нэрийг нь сонсож, үзэж байгаагүй болохоор олзуурхан бичиж авсан юм.

Равжаагийн бүтээлийг хэвлэсэн эмхтгэлүүдэд «Орчлонгийн явдал», «Орчлонгийн жам», «Элдэв Орчлонгийн явдал», «Ертөнц авгайн жам», «Ертөнцийн жам ёсыг жишээнд авсан нь» гэх зэрэг ертөнцөд зөв зүйтэй шударга аж төрөх арга ухааныг сургасан сургаалын зохиол нэлээд байгаа боловч өмнө дурдсан зохиолтой адил нэртэй сургаал одоогоор хэвлэгдээгүй бололтой байна.

«Орчлонгийн алтан товч» нэртэй сургаалыг зохиогч анх төвд, Монгол хэлний алинаар зохиосон нь тодорхойгүй бөгөөд Балжирмаа гуай «Ноён гэгээний сургаал» гэсэн нэртэй уйгуржин монгол үсгээр бичсэн эх байсан гэсэн мэдээ, түүний шинэ үсгээр тэмдэглэсэн эх бидний гар дээр байна. Уг сургаал нь нийт 200 шахам мөр шүлгээс бүрдэнэ. Эртний Энэтхэг, Төвдөөс уламжлалтай, хүний мэдлэг боловсрол, төрх байдал, зан суртахууны харилцаа, аж амьдрал зэргийг сайжруулах чиглэл хандлагатай сургаалын зохиолыг «номын ёсны», «хүнлэг ёсны» буюу «ертөнцийн ёсны», номын болон ертөнцийн ёсыг хоёуланг сургасан зохиолыг «хос ёсны» сургаал гэж авч үздэг.

Ертөнцөд аж төрөх арга ухааны талыг голлож сургасан сургаалыг «Хүнлэг ёсны»\* буюу «Ертөнцийн ёсны» сургаал гэдэг. Тэгэхлээр бидний өгүүлж байгаа «Орчлонгийн алтан товч» сургаал нь ертөнцөд зөв зүйтэй шударга аж төрөх арга ухааныг голлон номносон байгаа болохоор «хүнлэг ёсны» сургаал гэж хэлж болох талтай юм.

Равжаа «эв нөхөрлөл», «эвтэй найртай» байх үзэл санааг эрхэмлэн үздэг, ертөнцийнхнийг ч тийм байгаасай гэж хүсдэг учраас өөрийнхөө олон бүтээлд энэ санаагаа илэрхийлж, сургасан байдаг. Равжаа «Хавар цагийн зугаа» хэмээх сургаалдаа:

\* мөн ийм сургаалыг «Төр ёсны» сургаал ч гэж нэрлэдэг тал бий.

Эвгүй бол, эх хөвгүүн хоёр ч бол дайсан  
 Эвтэй бол энгийн хар элэгт хүн ч бол садан  
 Эвтэй боловч ах дүү мэт тустай нөхөр цөөн  
 Элдэв жаргал, зовлон өнчрөхгүй гэгч эвийн эрдэм<sup>4</sup>... гэж хүмүүс хоорондоо эв  
 найрамдлыг эрхэмлэхийн учрыг сургасан бол «Орчлонгийн алтан товч»-доо  
 Эрдэмтэн боловч, эвтэй бол нэн сайн  
 Эд мал ихтэй боловч, ухаантай бол нэн сайн  
 Эвгүй хүн нөхөртөө тусгүй гэх ч байтугай, биендээ гай болох магад  
 Эцсэн уналга эзэндээ тус болох байтугай, аминдаа гарз болж мэднэ...

гэх мэт олон мөр шүлгээр эрдэмтэн, эд мал, эр эм, элгэн садан, эгэл нөхөд зэргээр зүйрлэн  
 ертөнцийнхөнтэй зохицож явах нь ертөнцийн хүмүүний гол чухал зүйл бөгөөд ертөнцөд аж  
 төрөхөд тус болно гэдгийг сургасан байна.

Равжаа ингэж «Орчлонгийн алтан товч» сургаалдаа үнэнч шударга эвтэй найртай  
 нөхөрсөг явах, эрдэм сурах, ажилч хөдөлмөрч, эцэг эх, ахмад настанг хүндэлж байх зэрэг  
 ертөнцөд аж төрөх арга ухааныг олон талаас нь зөв зүйтэй сургасан байна.

«Орчлонгийн алтан товч» зохиолыг зөвхөн «хүнлэг ёсны» сургаалын талаас нь  
 төдийгүй яруу найраг, гүн ухааны үзэл зэрэг олон талаас авч үзэж болох талтай юм.  
 Равжаагийн яруу найргийн бүтээлд дан нэг хоёр үсгээр толгой холбон бичигдсэн томоохон  
 хэмжээний зохиол цөөн байна. Жишээлбэл: «Аврал бүхэн хурсан», «А үсгийн дуу»,  
 «Заяаны хирээр», «У үсгээр холбосон нь» гэх мэт «А, З, У» үсгээр дагнан толгой холбосон  
 жижиг зохиолууд байна.

Бидний өгүүлж байгаа «Орчлонгийн алтан товч» бол бүх мөрийг «А, Э» хоёр үсгээр  
 дараалан дагнан толгой холбосон зохиол юм.

Гэвч уг сургаалд зарим нэг мөрийн толгойг өөр үсгээр эхэлсэн явдал байгаа бөгөөд  
 энэ нь уг зохиол анх уйгуржин монгол үсгээр байсныг гэрчилж байна. Жишээлбэл: «Уур  
 хүрэхийн зоргоор учиргүй хашгичваас галзуу тай адил» гэсэн мөр шүлгийн эхний үгийг  
 уйгуржин монгол үсгээр «агуур- » гэж «А» үсгээр толгой холбон бичсэнийг шинэ үсэгт  
 буулгах даа «Уур» гэж сийрүүлсэн байна. Энэ нь уг зохиолын эх уйгуржин монгол үсгээр  
 бичсэн байсан гэж Балжирмаа гуайн хэлснийг давхар нотолж байгаа баримт мөн.

Мөн зарим мөрийн толгойг, анх уйгуржин үсгээр бичсэн хүн юмуу эсвэл шинэ үсгээр  
 тэмдэглэж авсан хүн хоёрын аль нэг нь алдсан байж болох юм.

Равжаа «Орчлонгийн алтан товч» сургаалаа зөвхөн толгой холбон зохиохыг  
 эрхэмлэсэнгүй сүүл холбох ёсыг хэрэглэсэн нь нэлээд тохиолдож байна. Жишээ нь:

Адгуус малыг олон баян гэж бардаж болохгүй  
 Ааш зангаа хурцатгаж хүнээс дээр болохгүй  
 Амьдын жаргалд ташуурч алс хойтыг орхиж болохгүй  
 Адаг биеэ шинжлэхгүй бусдын гэмийг отоож болохгүй...

гэх мэтээр «А» үсгээр толгой холбохын зэрэгцээ төгсгөлийн «үгээр» ижилсүүлэн давтан  
 холбосон байна. Мөн үүний зэрэгцээ төгсгөлийг «үс гээр» буюу нөхцөл дагавараар  
 ижилсүүлэн давтан холбосон ч байна,

Жишээ нь:

Авах гээхийн ялгалыг андууралгүй мэдэж  
Арга заль тэргүүтнийг андууралгүй орхиж  
гэх мэтээр «Ж» үсгээр нэлээд хэдэн мөр шүлгийг дагнан холбосон байна.

Ингэж Равжаа толгойг үсгээр, сүүлийг үгээр, үсгээр холбохын хамт монгол шүлгийн холбон найруулах нэг үндсэн зарчим болсон толгой, сүүлийг «үгээр» давтан холбох аргыг ч бас хэрэглэсэн байна. Жишээ нь:

**Аливаа** амьтны эс өрөвдөөс буянтай сэтгэлээс хагацсан **хэмээмой**

**Аливаа** явдлын зөвийг эс мэдвээс буруу үзэлтэн **хэмээмой**...

гэх мэт.

Ийнхүү Равжаа уг зохиолдоо монгол шүлгийн толгой, сүүл холбох олон арга хэлбэрийг чадамгай хослуулан хэрэглэсэн нь түүний холбон найруулах ур чадвар, авьяас, билэгийн онцлог өвөрмөц тал зэргийг тодорхой харуулж байна.

Равжаа «Орчлонгийн алтан товч»-доо ертөнцөд аж төрөх арга ухааныг сургахдаа монгол шүлгийн холбон найруулах аргыг чадамгай ашиглан уран яруу хэллэгээр товч тодорхой дүрслэхийн хамт гүн ухааны үзлийн талаар өөрийн баримталдаг «төв үзэл»-ийн ойлголтоо илтгэсэн байна. Жишээ нь:

Амьтны тусад санаа зориулж

Айж байвч тусыг хичээвээс **өглөгт хамаатай**

Ариун бусыг тэвчиж

Ариун явдлыг хичээж тангаргаа сахиж явбаас **шагшаабадид хамаатай**...

гэх мэт ертөнцөд зөв зүйтэй аж төрөх арга ухааныг сургаж байгаа сургаалаа «Зургаан билэг барамид»-тай холбож байгаагаар түүний гүн ухааны үзэл илэрхийлэгдэж байна.

Ч. Жүгдэр Агваанбалдангийн (1797—1864) «Вума ла жугли цэгдэл» гэдэг номын тухай хэлэхдээ «Агваанбалдангийн энэхүү зохиолын гол утга нь... тухайлбал 6 барамидад хураангуйлж өгүүлсэнд оршино... Тухайлбал энэхүү билэг барамид бол уг зохиолын гол хэсэг, гол агуулгыг тодорхойлж буй...»<sup>5</sup> гэсэн байна.

Тэгэхээр Равжаа ч «Орчлонгийн алтан товч» зохиолдоо аж төрөх арга ухааныг сургахын хамт «төв үзлийн» санаагаа «6 билэг барамидад» маш энгийн хэн бүхэнд ойлгогдох байдлаар илэрхийлсэн гэж үзэж болох юм.

Энэ бүгдийг хамтатган Равжаагийн «Орчлонгийн алтан товч» хэмээх сургаалыг дүгнэж үзвэл: Равжаагийн зохиол бүтээлийн тоонд шинээр орж бүртгэгдэж байгаа энэ зохиол нь сургаалын зохиолын хувьд «Хүнлэг ёсны» сургаал, зохиомжийн хувьд монгол шүлгийн холбон найруулах олон аргыг чадамгай ашигласан, мөн зохиогчийн гүн ухааны үзлийг илтгэсэн болно.

Иймд «Орчлонгийн алтан товч» хэмээх зохиол нь Равжаагийн «Хүнлэг ёсны» сургаал, монгол шүлгийн зүй тогтол болон өвөрмөц тал, зохиогчийн гүн ухааны үзлийг судлахад судалгааны чухал дурсгал, эх хэрэглэгдэхүүн болж өгөх нь дамжиггүй юм. Уг зохиолын бүрэн эхээс шинжлэх ухааны үзэлд үл нийцэх өнөө үеийн уншигчдад мэдээжээр үл таалагдах

«Амны уншлага маань тэргүүтэн  
Аль мэдэхээ тасралтгүй бүтээж»

гэх буюу

«Энэ насыг мөнхгүй гэгчийг үүрд санаж

Эргүүлэн бодож орчлонгоос уйд» гэх мэт мөрүүдийг хасч цэгээр орлуулан бусдыг хэвээр үлдээн сийрүүлэв.

Ер нь Равжаагийн монгол, төвд хэлээр бичсэн бүтээлээс урьд өмнө нийтлэгдээгүй ганц нэг зохиол мэдэгдэж олдож болох боломжтой тул цаашдаа тэдгээрийг сурвалжлан судлаачид болон нийт уншигчдад толилуулахыг эрмэлзэх болно.

### ОРЧЛОНГИЙН АЛТАН ТОВЧ\*

Ум сайн амгалан болтугай  
Ертөнцийн нэгэн өвгөн хар хүмүүн бээр  
Ер дэмий үг үсгийг хүүхэд сургахын тулд хэрэглэж  
А, Э толгойгоор дараалж  
Алиалж хэлж бичив.

Аливаа өгөх авах тэргүүтэнд гарз бэрхшээл саналгүй хичээж  
Арван хар нүглийг ахуй наст тэвчиж  
Арван цагаан буяныг арвижуулан шамдаж  
Авах гээхийн ялгалыг андууралгүй мэдэж  
Арга заль тэргүүтнийг анхааралгүй орхиж

Аажим урт санаа алдаршлахгүй бодож  
Ах дүү нартайгаа ханилах ёсыг  
Ая дүйг авч олж нөхөрлөх  
Аж төрөхийн байдлыг  
Асар нягт шинжлэн бүтээ.  
Адгуус малаа ариглан хамгаалж малла  
Атгаг урин сэтгэлийг тэвчиж  
Алиа чалчаа үгээн цөөтгөж.  
Адаг биеэ дээрэмхүйд санаж бардалгүй  
Ахмад настанг насад хүндэлж  
Арга үгүй ядмаг дордсыг  
Алгасал үгүй тэтгэмжилж урамшуулж  
Арга мэхтэй зэвүүн ааштныг болгоомжтойгоор өнгөрүүл.  
Арван хоёр цагийн улиралд  
Ая эвийг олж нутагла  
Айл дэмий хэсэх тэргүүтэн  
Аж төрөхөд тусгүй  
Алс хойтод, буянгүй явдлыг орхиж  
Аливаа самуун наадам тоглоомын амтанд ташуурч  
Амиа тэмцтэл согтууран галзуурах  
Архи тамхи хоёр хэмээх ч

\*Б. Балжирмаагийн шинэ үсгээр буулгасан бүрэн эхээс дам хуулбарлан удаа нийтлүүлж буй бүрэн эх (Р. Б)

Алс эдүүгээ хоёрыг бузарлах тул  
 Ашид тусгүй явдлыг орхиж  
 Авах өгөх тэргүүтэн  
 Аж юмаан нарийвчлан бодолгүй  
 Аль олдох чинээгээр өр шир хийх хэрэггүй.  
 Амь зуухыг хичээж хулгай худал хийх хэрэггүй  
 Ачитныг санаж аль чадахаар хариул  
 Айл муу нөхрөөс ажиглаж зайлах хэрэгтэй.  
 Аливаа юмны үнэн зөв чигийг олж мэдэх хэрэгтэй  
 Ам нь цангасан хүмүүн усыг хүсэх мэт  
 Ашид нясваа няст учирсан тул буяныг хүсэх хэрэгтэй.  
 Аргал түлээг ч бол шамдан цуглуулж  
 Аж төрдөг аар саар өчүүхнийг ч бол  
 Арвижуулж буяныг хураах хэрэгтэй.  
 Ам хамраа таглаж муухай үнэрээс жигших мэт  
 Алс хойтын үйлэнд харштай  
 Адал нүглийг аар саарыг ч бол тэвчих хэрэгтэй.  
 Ааш зангаа ажиглаж биеэ засах хэрэгтэй.  
 Авах бүрий хожихыг бодож  
 Алсдаан илүү болохгүй.  
 Аливаа учирсныг хуурахыг бодож нөхөртөө сайн болохгүй  
 Айлгах дийлэхийг бодож дээд сайн болохгүй  
 Алагчилж зусардагч өнгөтэй сайн болохгүй.  
 Амьд явах насыг мөнх санаж сайн болохгүй.  
 Адгуус малыг олон баян гэж бардаж болохгүй.  
 Ааш зангаа хурцатгаж хүнээс дээр болохгүй.  
 Амьдын жаргалд ташуурч алс хойтыг орхиж болохгүй  
 Адаг биеэ шинжлэхгүй бусдын гэмийг олох ч тусгүй  
 Асар ихийг хүсэх ч тусгүй  
 Аар саарыг чунлаж болохгүй  
 Алсдаан дайран ирэхийг тохиолдуулж буян хийх гэж байж хоцорвоос тусгүй  
 Анх нэг үүссэн санааг санасаар  
 Аль олдох чинээгээр буянтай мөрт зориулваас буян болж болно.

Ах дүү муу сэтгэлтэй бол дайсантай адил  
 Харь хамаагүй хүмүүн ч бол санаа нийлэлцэж  
 Сайн сэтгэлтэй бол садан лугаа адил.  
 Амны зоргоор ухаангүй үг үгүүлвээс согтуу чалчих адил.  
 Уур хүрэхийн зоргоор учиргүй хашгичнаас галзуутай адил.  
 Аминчлахыг хичээгээд байвал ганцаардахад хялбар  
 Аж төрөхөөн хямгадалгүй  
 Арилгаж үрээд байвал хоосорход хялбар.  
 Атаат хартай сэтгэлээн сайн бодвоос жигшүүртэй болоход хялбар  
 Аливаа амьтныг эс өрөвдөөс буянтай сэтгэлээс хагацсан хэмээмой.  
 Аливаа явдлын зөвийг эс мэдвээс буруу үзэл хэмээмой.  
 Аливаа юмыг асар харамлалгүй  
 Аар саар ч бол эрх биш өг  
 Аль мэддэг номоон  
 Амьтны тусад санан зориулж  
 Айж байвч тусыг хичээвээс өглөгт хамааралтай  
 Ариун бусыг тэвчиж

Ариун явдлыг хичээж тангаргаан сахиж явбаас шаг шаабадид хамаатай,  
Уураан тэвчиж номхон дөлгөөнийг хичээвээс хүлцэнгүйд хамаатай.  
Ашид үг санаа явдал цөмийг хичээн зөв буяны мөрт оруулж  
Алдал онолд залихай буруу явдал бүхнийг тэвчээд явбаас хичээнгүйд хамаатай.

Амьтныг энэрэхгүй сэтгэлд  
Алагсал үгүй болбоос диянд хамаатай  
Аливаа Дээдийн номыг уйтгаргүй шамдаж  
Андуурах олхио чалчаа үгээн тэвчвээс билэгт хамаатай.  
Ашид бүтэхийн зургаан барамидыг  
Аль амар хямд захаас нь ч бол бүтээн  
Ажран эвдрэх зургаан барамидаас хагацваас  
Алсдаан тустай гэгчийг уурлалгүй уужим санан бодож явалтай  
Эрдэнэт хүний биеийг олж  
Энэ сайхан чөлөө учрал бүрдэж  
Эрхэм дээд шашин лугаа барилдаж төрсөн нь  
Эртний үйлдсэн буяны хүч болой

Эд барааг ч бол  
Элэхгүй бөхийг бодож байтал  
Энэ хойтод тустай ном буяныг хичээж  
Эх болсон хамаг амьтны тусыг бүтээж үйлдэлтэй

Эцэг эх багш тэргүүтэн ачитны ачийг  
Эрх биш хариулан бодож тусыг ихэтгэх  
Эзэн дээдийн албанд гавьяа зүтгэлээ хичээ  
Эх болсон хамаг амьтныг  
Энэ тэр хэмээлгүй энэр  
Эгнэгт буяны зүгт шамдан аливаа аж төрөхийг эрэгцүүлэн хямгад  
Энгийн зэргийн олон нөхөдтэй эв аян хичээ  
Эелдэг зөөлөн зан зангаас этгээд гажуу ааш занг эгнэгт тэвч  
Эрэх хүсэхдээн буяныг хүс  
Энэ хойт хоёрыг хорлогч нүгэл хилэнцийг тэвч  
Эгэл дорд биеэн би гэж битгий магт  
Эрэгцүүлж амь зуухыг хичээж хулгай битгий хий  
Эрхгүй үймж хөөрөвч худлаа битгий хэл  
Энэ насыг мөнхгүй гэгчийг үүрд санаж

Эргэх дөрвөн улиралд эвийг олж нутагла  
Эмгэг зовлонтой боловч саднаа тэтгэ  
Эцэс турсан боловч малаа торд  
Эрхийг оловч дордсыг тэтгэ

Эс мэдсэнээн битгий мэдэнгүйрэх  
Эрдэм сурахыг үйлдэвч уйдал үгүй авьяас шавь  
Эрж горьдох олзонд их битгий шуна  
Эртний буянаар учрах заяа мэдэх буйзаа

Эвгүй хэдэр болбоос садангүй ганцаардах  
 Этгээд муу санаа өөрийн биеийг хорлох  
 Эм дом мэт сайхан санаатай бол эгнэгт ганцаардахгүй  
 Элдэв үйлст бүтэмжтэй  
 Энэ хойтод тустай буйзаа  
 Эрхтэй сайн боловч ихээр авах хэрэггүй  
 Эрдэмтэй баян боловч омгорхохын хэрэг үгүй  
 Эргүү тэнэг болвоос өөрийн хирийг мэдэж явбаас сайн  
 Эс мэдэж биеэн тоовоос хэрэг үгүй  
 Эрдэмтэй цэцэн боловч  
 Энэрэлтэй зөөлөн зантай болвоос сайн  
 Эрэлхэг хатуу сэтгэлт  
 Энэрэлгүй атаач болвоос тусгүй  
 Энэ цагийн жам нь сэрэмж хэрэгтэй боловч  
 Эгнэгт хардаж болохгүй  
 Энэ насны турш байтугай өдөр бүрийн явдал адилгүй

Энд чөтгөрийг битгий итгэ  
 Эсэргүүцэх дайсан учрах цаг ирвээс  
 Өөрийн биенээс ч бол гарч одох  
 Энэ учрах үйл явдал нь сэтгэлийн сайн муугаас бүтдэг  
 Энэ насны ашгийг үүрд бодсоноос  
 Эцэс хойтын тусыг бодвол туйлбартай  
 Эрдэмтэй боловч эвтэй болвоос нэн сайн  
 Эд мал ихтэй боловч ухаантай бол нэн сайн  
 Эвгүй хүн нөхөртөө тусгүй гэх ч байтугай биедээн гай болох магад  
 Эцсэн уналга эзэндээ тус болох байтугай аминдаа гарз болж мэднэ  
 Эм муутай хар хүн удтал санаа амаргүй  
 Эмээл муутай морь удтал нуруу амаргүй  
 Эвтэй болоод эцэг эх хайртай болвоос садан зуур өмөгтэй  
 Эмээл хазаар сайн болвоос уналга унахад түшигтэй  
 Эзэнд түшигтэй болвоос харь халуун хоёрт түшигтэй  
 Энгийн олон нөхөд луугаа эвтэй болвоос  
 Эд явдал бүтэмжтэй  
 Энэ ертөнцийн жам явдал хязгаарлашгүй олон үндэсний үйлийн үр  
 Эдүүгээ барилдаж төрсөн сэтгэлийн авьяас гурван чанар  
 Энэ цэвүүн цагийн байдлын тул  
 Энэ хойтын зав тусыг  
 Эрэгцүүлэн бодож үйлдэхийг тасалдуулж болохгүй хэмээн  
 Э, А толгойгоор холбож  
 Элдэв чалчаа үг бичив.

### ЗҮҮЛТ ТАЙЛБАР

1. Ноён хутагт Д. Равжаа. Зохиолын эмхтгэл, Эрхэлсэн Ц. Дамдинсүрэн, Эмхтгэл хэвлэлд бэлтгэсэн Д. Цагаан УБ., 1962
2. Ч. Алтангэрэл, Монгол зохиогчдын төвдөөр бичсэн бүтээл. II дэвтэр (Д. Равжаа) УБ. 1968
3. Ц. Дамдинсүрэн, Mongvol uran jokiyal-un degeji javum bilig orusibai «Мон

- голын дурсгал бичгийн чуулган» 14 боть 1959, 452—458, Ноён хутагт Равжаа «Соёл утга зохиол». 1961, No 8., Монголын уран зохиолын тойм, III дэвтэр. 1968 -р тал. Ч. Жүгдэр, 3. Агваанбалдангийн гүн ухааны үзэл, УБ., 1978, 29—38,
- Г. Лхагвасүрэн, Д. Данзанравжаагийн нийгэм-зан суртахууны үзэл «ШУАМ» 1985, № 1, 64—73.
- Р. Занабазар, Говийн их найрагч Равжаагийн уран бүтээлийн асуудалд, Сайншанд, 1960
- С. Лувсан, Д. Равжаа түүний зохиолын тухай зарим мэдээ «Хэл зохиол судлал» X боть, 13-р дэвтэр. УБ, 1976, 131—143
- Ч. Нямдорж, Равжаагийн зохиол дахь гүн ухааны санаа «Шинжлэх ухаан, амьдрал, 1985, № 5, 57—60
- W. Hriszig, Geschichte der mongolischen Literatur, Band I, Wiesbaden, 1972. p. 185—240
- Л. Хүрэлбаатар. Равжаагийн уран бүтээлд холбогдох зарим шинэ мэдээ «ШУАМ» 1986. № 2 96-105
- Д. Цагаан, Д. Равжаа (1803-1856) Монголын уран зохиолын тойм. 3-р дэвтэр (XIX зууны үе) УБ, 1968, 5—44
- Д. Цэрэнсодном, Равжаагийн уран бүтээлийг судалж байгаа нь «Хэл зохиолын судлал» IV боть, дэвтэр 1—4, УБ., 1966, 204—212-р тал, зэрэг Д. Равжаагийн талаар судалгаа хийсэн гадаад, дотоодын олон эрдэмтдийн бүтээлийг дурдаж болно.
4. Ноён хутагт Д. Равжаа, Зохиолын эмхтгэл. УБ., 1962., 311-р тал
5. Ч. Жүгдэр. 3. Агваанбалдангийн гүн ухааны үзэл. УБ, 1978, 219